

ТАНИЛЦУУЛГА

*ОУЭШ-ийн Ромын дүрмийн
“Түрэмгийллийн гэмт хэргийн тухай
болон дайны гэмт хэргийн тухай”
нэмэлт, өөрчлөлт*

Олон улсын эрүүгийн шүүх (*цаашид “ОУЭШ” гэх*)-ийн дүрмийг 1998 оны 7 дугаар сарын 18-нд Италийн Ром хотноо баталж, 2002 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Монгол Улс ОУЭШ-ийн дүрэмд 2000 оны 12 дугаар сарын 29-нд гарын үсэг зурж, 2002 оны 4 дүгээр сарын 5-нд соёрхон баталсан.

ОУЭШ-ийн Ромын дүрмийг 1998 онд батлах үеэр түүнд оролцогч талууд түрэмгийллийн гэмт хэрэг, мөн уг гэмт хэргийн шүүхийн харьяалал, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн оролцооны талаар өөр өөр байр суурьтай байсан учраас түрэмгийллийн гэмт хэргийг ОУЭШ-ийн Ромын дүрэмд тодорхой тусгалгүйгээр баталсан байдаг. ОУЭШ-ийн Ромын дүрэм хүчин төгөлдөр болсны дараа буюу 2002 оны 9 сард түрэмгийллийн гэмт хэргийн асуудлаар байгуулагдсан Тусгай ажлын хэсэг нь 2009 оны 2 дугаар сард Ромын дүрмийн оролцогч талуудын нэгдсэн хуралдаанд уг гэмт хэргийн талаарх саналаа танилцуулж, саналыг үндэслэн боловсруулсан төслийг Уганда Улсын Кампала хотноо 2010 оны 5 дугаар сарын 31-нээс 6 дугаар сарын 11-нд болсон ОУЭШ-ийн Хяналтын бага хурлын үеэр хэлэлцүүлж ОУЭШ-ийн Ромын дүрэмд “Түрэмгийллийн гэмт хэргийн тухай” нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байдаг.

Дээрх нэмэлт, өөрчлөлтөөр ОУЭШ-ийн Ромын дүрмийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасч, 8 *bis* дугаар зүйлийг нэмж оруулсан бөгөөд тус зүйлээр батлан хамгаалахын, эсхүл улс төрийн шууд оролцоотой буюу удирдах албан тушаалтан тус гэмт хэргийн (үйлдэгч) субъект болохоор заасан нь Ромын дүрэмд дурдсан бусад 3 төрлийн олон улсын гэмт хэргээс ялгаатай юм.

Мөн Ромын дүрмийн 13 дугаар зүйлийн (а) болон (с) дэд хэсэгт нийцүүлэн түрэмгийллийн гэмт хэргийг Шүүх хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар зохицуулсан 15 *bis* дугаар зүйл нэмсэн. Уг зүйлийн дагуу түрэмгийллийн үйлдэл гэж тооцоход НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн дүгнэлт заавал гарах хэрэггүй бөгөөд оролцогч улс эсхүл ОУЭШ-ийн дэргэдэх прокурор түрэмгийллийн үйлдэл гэж үзэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд мөрдөн байцаалтыг эхлүүлэх эрхтэй байхаар болсон. Мөн энэ зүйлээр түрэмгийллийн гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд 2 төрлийн хязгаарлалт тогтоосон. Нэгдүгээрт, Ромын дүрмийн оролцогч биш улсын иргэн, эсхүл түүний нутаг дэвсгэрт түрэмгийллийн гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд шүүх тус хэргийг

харьяалан шийдэхгүй. Хоёрдугаарт, аливаа оролцогч улс түрэмгийллийн гэмт хэргийн хувьд ОУЭШ хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ тусгайлан мэдэгдсэн тохиолдолд уг гэмт хэргийн таслан шийдвэрлэх ажиллагааг ОУЭШ явуулахгүй байхаар тусгажээ.

НҮБ-ын дүрмийн 39 дүгээр зүйлд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл "түрэмгийлсэн үйлдэл" байгаа эсэхийг тодорхойлно гэж заасны дагуу түрэмгийллийн гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд Аюулгүйн Зөвлөлөөс ОУЭШ-д шилжүүлэх нөхцөлийг тодорхойлсон заалт бүхий 15 *ter* дугаар зүйлийг Ромын дүрэмд нэмж оруулсан.

ОУЭШ-ийн Ромын дүрмийн "Түрэмгийллийн гэмт хэргийн тухай нэмэлт, өөрчлөлт"-ийг одоогоор 35 улс соёрхон баталсан бөгөөд 2018 оны 7 дугаар сарын 18-нд хүчин төгөлдөр болсон.

Түүнээс гадна Кампалагийн ОУЭШ-ийн Хяналтын бага хурлын үеэр Бельги Улсын санаачилгаар "гэмт хэргийн шинж"-ийн тухай "олон улсын шинжтэй бус зэвсэгт мөргөлдөөний үед химийн зэвсэг болон тэлэгч сум хэрэглэсэн тохиолдолд дайны гэмт хэрэгт тооцох" заалт оруулахаар болсон. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг одоогийн байдлаар 34 улс соёрхон батлаад байна. Уг нэмэлт, өөрчлөлт 2012 оны 9 дүгээр сарын 26-нд хүчин төгөлдөр болсон.

Мөн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан Хүний эрхийн төлөв байдлын дүгнэлтийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас "Ерөнхий төлөвлөгөө батлах тухай" 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 204 дүгээр тоот тогтоолыг баталсан. Энэхүү тогтоолын хавсралтад тусгасан зөвлөмж 108.17-д "ОУЭШ-ийн Ромын дүрмийн зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжид тусгах", 108.18-д "ОУЭШ-ийн Ромын дүрэмд үндэсний хууль тогтоомжийг бүрэн нийцүүлэх" гэж тус тус заасны дагуу дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай юм.

ОУЭШ-ийн Ромын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталснаар Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах бөгөөд ийнхүү өөрчлөлт оруулснаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, тухайлбал ОУЭШ-ийн Ромын дүрэмд заасан нэр томъёотой уялдуулж, нэг мөр болгох юм.

Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28¹.1-д "Засгийн газар Улсын Их Хурал соёрхон батлах хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээний эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, шаардлагатай бол түүний орчуулга, гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээний хувьд тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд зөвшилцөх, хэлэлцүүлэхээр ирүүлнэ" гэж заасны дагуу дээрх

нэмэлт, өөчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар зөвшилцөх, хэлэлцүүлэхээр хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР